



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

ЕХ-НЫ ШИНЭЧИЛСЭН ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот
2019 он



This project is funded
by the European Union.

Төслийн Санхүүжүүлэгч Европын холбоо

Орчуулж эмхэтгэсэн: Ч.Цэцэгмаа

Хэвлэх хэмжээ: B5 /176x250мм/

Хэвлэлийн хуудас: 7х.х



“Эрдэнэзул” ХХК-д
хэвлэв.

АГУУЛГА

1. Өмнөх үг	4
2. ЕХ-ны шинэчилсэн ХЕС-ийн журам /978/2012/	5
I бүлэг: Нийтлэг зүйл	12
II Бүлэг: Ерөнхий зохицуулалт	14
III Бүлэг: Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалт	17
IV Бүлэг: Нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай зохицуулалт	21
V Бүлэг: Түр цуцлалт ба нийтлэг бүх зохицуулалт	17
VI Бүлэг: Хамгаалалтын арга хэмжээний тухай зүйл	25
VII Бүлэг: Нийтлэг заалтууд	29
VIII Бүлэг: Төгсгөлийн заалтууд	32
3. Хавсралт I: 3 дугаар зүйлийн дагуу Хөнгөлөлт эдлэгч орнуудын жагсаалт	33
Энэхүү системийн 3 дугаар зүйлийн дагуу бүхэлдээ болон зарим нэр төрлийн барааны үечилсэн тарифын бууралттай орнууд	38
4. Хавсралт II: Зүйл 1(2)-ийн дагуу ерөнхий хөнгөлөлтөд хамрагдсан орнууд	38
Зүйл 1(2)-ийн дагуу бүхэлдээ болон зарим барааны хувьд үечилсэн тарифын бууралттай ерөнхий хөнгөлөлтөд хамрагдсан орнууд	40
5. Хавсралт IV: Зүйл 1(2)-ийн с заалтад дурдсан тусгай хөнгөлөлтөд хамрагдсан нэн буурай хөгжилтэй орнууд	41
Зүйл 1(2)-ийн с заалтад дурдсан тусгай хөнгөлөлтөд хамрагдсан бүхэлдээ болон тодорхой барааны хувьд үечилсэн тарифын бууралттай нэн буурай хөгжилтэй орнууд	42
6. Хавсралт V: Хамтын нийгэмлэгийн тарифын хөнгөлөлтийн ерөнхий системд хамрагдах улсууд болон нутаг дэвсгэр	43
I (2) (а) болон (б) зүйлд заасан зохицуулалтад хамаарагдах барааны жагсаалт	51
7. 9 дүгээр зүйлд заасан конвенцууд	80
А хэсэг: Хүний эрх, хөдөлмөрийн эрхийн тухай НҮБ, ОУХБ-ын гол конвенцууд	80
Б хэсэг: Байгаль орчин, засаглалын зарчмын тухай конвенцууд	81

ӨМНӨХ ҮГ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас Европын Холбоо (ЕХ)-ны санхүүжилттэй Монгол улсын худалдааг дэмжих ТРАМ төсөлтэй хамтран “ЕХ-ны шинэчилсэн Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн танилцуулга” хэмээх шинэчилсэн гарын авлагыг бизнес эрхлэгч та бүхэнд толилуулж байна. Энэхүү гарын авлагыг МҮХАҮТ-аас эрхлэн 2006, 2017 онуудад хэвлүүлж олны хүртээл болгосон билээ.

Европын Холбоо(ЕХ) 1971 оноос эхлэн дэлхийн хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжил, экспортыг дэмжих үүднээс худалдааны хөнгөлөлтийн нэг хэлбэр болох импортын гаалийн тарифын хөнгөлөлт олгох систем буюу “Хөнгөлөлтийн Ерөнхий Систем” (ХЕС)-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд гурван жил тутам шинэчилж импортын тарифыг тууштай бууруулах бодлого баримтлан, хэрэгжүүлж байна.

Монгол улс ЕХ-ны Ерөнхий Хөнгөлөлтөд 1991 оноос хамрагдаж ирсэн бөгөөд экспортын голлох бараанууд, тухайлбал: нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүнүүд хамрагдаж 9.6%-ийн татвартай байсан бол шинэчилсэн ХЕС-ийн дагуу нэн тааламжтай нөхцлөөс ч илүү 0 тариф хүртэл буурсан байна.

Шинэчилсэн ХЕС-д хамрагдсанаар Монгол улсаас гарал үүсэлтэй 7200 (6300) орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүн гаалийн татваргүй нэвтрэх боломжтой болсон юм. Энэ нь манай экспортын бараа, бүтээгдэхүүн Европын Холбооны зах зээлд ижил төрлийн өрсөлдөгч бүтээгдэхүүнээс хямд өртгөөр нэвтрэх давуу талтай болж үйлдвэрлэл, экспорт, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэхэд чухал дэмжлэг болох юм.

Тус гарын авлагад Европын Парламент болон Европын Холбооны Комиссоос 2012 оны 10 сарын 25-д шинэчлэн баталсан 978/2012 тоот журам болон хөнгөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг тусгасан бөгөөд шинэчилсэн журам нь 2023 оны 12 сарын 31 хүртэл үйлчлэх юм.

Таны бизнесийн үйл ажиллагаанд амжилт хүсье.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

ЗӨВЛӨЛИЙН ЖУРАМ**Зөвлөлийн журам (ЕХ) № 978/2012**

2012 оны 10 дугаар сарын 25

**ЕХ-ны Зөвлөлийн № 732/2008 тоот журмыг хүчингүй болгох,
Хөнгөлөлтийн Ерөнхий Системийг хэрэгжүүлэх тухай**

Европын Парламент болон Европын Холбооны зөвлөл,

Европын Холбоог байгуулсан Гэрээ, ялангуяа гэрээний 207 дугаар зүйл,

Европын Комиссын санал,

Үндэсний парламентад хуулийн төслийг өргөн барьсны дараа,

Энгийн хууль журмуудыг даган биелүүлэх зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр:

(1) Тус хамтын нийгэмлэг нь 1971 оноос хөгжиж буй орнуудад Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дагуу худалдааны хөнгөлөлтийг хэрэгжүүлж эхэлсэн.

(2) Хамтын нийгэмлэгийн нэгдсэн худалдааны бодлого нь Хамтын нийгэмлэгийн гадаад үйл ажиллагааны ерөнхий заалтуудад тусгагдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Энэ нь ЕХ-ны Гэрээний 21 дүгээр зүйлд тусгагдсан

Хамтын нийгэмлэг нь хөгжиж буй орнуудын ядуурлыг бууруулах гол зорилго бүхий эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг хөхүүлэн дэмжих нийтлэг бодлого, үйл ажиллагааг тодорхойлох зорилготой.

(3) Хамтын Нийгэмлэгийн худалдааны нэгдсэн бодлого нь Европын Холбоог байгуулсан тухай гэрээний 208-р зүйлд ззасны дагуу хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд Хамтын Нийгэмлэгийн хөгжлийн бодлогын гол зорилтуудтай харилцан уялдах, ялангуяа ялангуяа хөгжиж буй орнуудад ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжихэд чиглэнэ.

Энэ нь ДХБ-ын шаардлагууд, нэн ялангуяа 1979 онд Тариф Худалдааны Ерөнхий Хэлэлцээр (ТХЕХ)-ийн хүрээнд батлагдсан гишүүн орнууд хөгжиж буй орнуудад илүү таагай ялгавартай нөхцөл олгох, харилцан хамаарал, оролцооны тухай зохицуулалтын (the ‘Enabling Clause’) -ийн заалтуудтай нийцэх ёстой.

(4) Европын Комиссоос 2004 оны 7 дугаар сарын 7-нд хүргүүлсэн ”Хөгжиж буй орнууд, олон улсын худалдаа ба тогтвортой хөгжил: 2006-2015 он буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих Хамтын нийгэмлэгийн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (ХЕС)-ийн үүрэг, хэрэглээ” гэсэн мэдээлэл нь 2006-2015 онд тарифын ерөнхий хөнгөлөлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамжийг тодорхойлсон.

(5) Зөвлөлийн 2008 оны 7-р сарын 22-ны өдрийн 732/2008 тоот журам нь 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжсэн ХЕС-ийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд Европын Парламент болон Зөвлөлийн 2011 оны 5-р сарын 11-ний өдрийн 512/2011 тоот журмаар сунгагдан, Зөвлөлийн 732/2008 тоот журмаар нэмэлт өөрчлөлт орсон байна. Энэхүү журам нь ХЕС-ийг 2013 оны 12 сарын 31 хүртэл хэрэгжих нөхцлийг хангасан байна.

Энэхүү журмын дагуу тарифын хөнгөлөлтийн систем нь нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан хугацаагүй тусгай хөнгөлөлтөөс бусад тохиолдолд хэрэгжиж эхэлсэн өдрөөс хойш 10 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

(7) ЕХ-ны зах зээлд тарифын хөнгөлөлттэй нөхцлөөр нэвтрэх боломжоор хангаснаар тус Систем нь хөгжиж буй орнуудад хөгжлийн үр ашгаа тэлэх хөрөнгө оруулалт хийх боломж бүхий нэмэлт орлогыг олон улсын худалдаанаас олох, улмаар эдийн засгаа төрөлжүүлэхэд нь туслах замаар ядуурлыг бууруулах, сайн засаглал, тогтвортой хөгжлийн зорилтоо хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

Тарифын хөнгөлөлтийн систем нь хөгжлийн болон худалдаа, санхүүжилтийн дэмжлэг ихээхэн шаардлагатай хөгжиж буй орнуудад туслахад чиглэгдэх ёстой.

(8) Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (цаашид систем гэх) нь хөнгөлөлтөд хамрагдагч бүх орнууд болон нутаг дэвсгэрт хамаарах ерөнхий хөнгөлөлт ба ижил төстэй хөгжиж байгаа орнуудын янз бүрийн хөгжлийн хэрэгцээг харгалзан үзсэн хоёр тусгай хөнгөлөлтөөс тус тус бүрдэнэ.

(9) Ерөнхий зохицуулалт нь хөгжлийн нэгдсэн хэрэгцээгээ хуваалцах, эдийн засгийн хөгжлийн хувьд ижил түвшний хөгжиж буй бүх орнуудад олгоно.

Дэлхийн Банкны ангиллаар өндөр болон дундаас дээш орлоготой орнуудын нэг хүнд ногдох орлогын түвшин нь тарифын хөнгөлөлтгүйгээр эдийн засгийн төрөлжүүлэлтийн түвшинг дээшлүүлэх боломжийг олгодог.

Тэдгээр орнууд төвлөрсөн эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг амжилттай хэрэгжүүлсэн эдийн засагтай юм.

Тэдгээр орнууд хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийн хөгжил, худалдаа ба санхүүгийн ижил хэрэгцээгээ хуваалцдаггүй, хөгжлийн харилцан адилгүй түвшинтэй, өөрөөр хэлбэл илүү эмзэг эдийн засагтай хөгжиж буй орнуудтай адилг биш бөгөөд шударга бус ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэхийн тулд тэдэнд ялгавартай хандах хэрэгтэй юм.

Цаашилбал, өндөр хөгжилтэй болон дундаас дээш орлоготой орнуудын хэрэгжүүлж буй хөнгөлөлтийн системийн дагуу тарифын хөнгөлөлт эдлэх нь ядуу, эмзэг эдийн засагтай орнуудын экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, улмаар шударга бус дарамтыг бий болгож болзошгүй юм.

Ерөнхий зохицуулалт нь улс орнуудын хөгжлийн болон худалдаа, санхүүгийн хэрэгцээ шаардлага өөрчлөгдөхийг харгалзан үзэх бөгөөд тухайн улс орны нөхцөл байдал өөрчлөгдсөн ч зохицуулалтыг нээлттэй хэвээр байх явдлыг баталгаажуулна.

Тогтвортой байдлыг хангахын тулд ерөнхий зохицуулалтаар олгосон тарифын хөнгөлөлтийг Холбооны зүгээс олгодог худалдааны ихэнх хэсгийг хамардаг зах зээлд нэвтрэх ижил түвшний хөнгөлөлттэй нөхцөл эдэлж буй орнуудад сунгахгүй юм.

Хөнгөлөлт эдлэгч улс болон эдийн засгийн операторуудыг журмыг хэрэгжүүлэхэд тохиромжтой цаг хугацаагаар хангахын тулд ерөнхий хөнгөлөлтийн зохицуулалт нь өргөдөл хүлээн авсан өдрөөс эхлэн 2 жил үргэлжилэх бөгөөд энэ тухайгаа хөнгөлөлт эдлэгч улсуудын жагсаалтад тусгах ёстой

2008 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн Европын Комиссын №732/2008, Европын Зөвлөлийн № 55/2008 журам нь Молдав Улсад олгосон бие даасан худалдааны хөнгөлөлтийг тусгасан бол 2000 оны 9-р сарын 18-ны өдрийн Европын Зөвлөлийн №2007/2000 тоот журам нь Европын Холбооны тогтвортой байдал ба Холбооны үйл ажиллагаанд оролцож буй улс орнууд, бүс нутгууд тухайн хөнгөлөлтийн системд хамрагдах боломжтой тухай тусгай худалдааны зохицуулалтыг тусгасан байна.

Холбоотой хамтран ажилладаг хилийн чанад дахь бүс нутгууд болон Европын Комиссын №732/2008 журмын Хавсралт 1 д тусгагдаагүй хилийн чанад дахь бүс нутгууд, улс орнууд энэхүү системд хамрагдах боломжгүй.

⁽¹¹⁾ Тогтвортой хөгжил, сайн засаглалыг урамшуулах тусгай хөнгөлөлт нь 1986 оны НҮБ-ын Хөгжих эрхийн тухай тунхаглал, 1992 оны Риогийн Байгаль орчин, хөгжлийн тухай тунхаглал, 1998 оны ОУХБ-ын Ажлын байрны үндсэн зарчим, эрхийн тухай тунхаглал, 2000 оны НҮБ-ын Мянганы Тунхаглал, 2002 оны Йоханнесбургийн Тогтвортой хөгжлийн тунхаглал зэрэг олон улсын конвенцууд болон арга хэрэгслээр хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн тухай ойлголтод тулгуурлана. Улмаар хүн ба хөдөлмөрийн эрх, байгаль хамгаалал, сайн засаглалын талаарх олон улсын үндсэн конвенцуудыг батламжлах, үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбогдуулан хүлээх хүндхэн үүрэг, хариуцлагыг нь харгалзан үзвэл барааны төрөлжилт багатай, олон улсын худалдааны тогтолцоонд хангалттай оролцдоггүй эмзэг эдийн засагтай орнуудад энэхүү тарифын нэмэлт хөнгөлөлт ихээхэн үр ашигтай юм.

⁽¹²⁾ Эдгээр хөнгөлөлт нь эдийн засгийн цаашдын өсөлтийг дэмжихэд чиглэсэн бөгөөд чингэснээр тогтвортой хөгжлийн хэрэгцээ, шаардлагад эерэгээр тусна. Энэ зохицуулалтын хүрээнд үнийн дүнд ногдуулах татвар болон биет хэмжээнд ногдуулах татварыг (үнийн дүнд ногдуулах татвартай хослоогүй тохиолдолд) хөнгөлөлт эдлэгч улсуудын хувьд хүчингүй болгоно.

⁽¹³⁾ Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтын шалгууруудыг бүрэн хангасан улс орнуудын хүсэлтийг Комисс хянан үзсэний дүнд тарифын нэмэлт хөнгөлөлтүүдийг эдлэх боломжтой бөгөөд энэхүү журмыг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн өргөдөл гаргах ёстой.

Мөн түүнчлэн Европын Комиссын 732/2008 тоот журмын дагуу тарифын хөнгөлөлт эдлэгч улс орнууд мөн шинээр өргөдөл гаргах ёстой.

⁽¹⁴⁾ Комисс нь хүний эрх, хөдөлмөрлөх эрх, байгаль орчныг хамгаалах, сайн засаглалын тухай олон улсын конвенцуудад нэгдэн орох болон эдгээр конвенцуудын доор байгуулагдсан холбогдох хяналтын байгууллагуудын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хяналт тавина.

Хоёр жил тутамд Комисс нь Европын Парламент болон Зөвлөлд хөнгөлөлт эдлэгч орнуудын холбогдох конвенциудад нэгдэн орсон тухай болон тухайн конвенцуудын дагуу хүлээсэн үүрэг амлалтуудын тайлангийн нийцтэй байдал, хэрэгжилтийн бодит байдлын тухай тайлагнана.

(15) Хяналт тавих, хөнгөлөлтийг цуцлах үйл ажиллагаанд холбогдох хяналтын байгууллагуудын тайлан нь маш чухал юм.

Мөн тайлангийн мэдээлэл нь үнэн зөв найдвартай бол бусад эх сурвалжуудаас мэдээллээ авсан байж болно. Эх сурвалжуудыг үл ялгаварлах үүднээс иргэний нийгэм, нийгмийн түншүүд, Европын Парламент, Зөвлөлийн мэдээллүүдийг оруулж болно.

(16) Нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай хөнгөлөлтийг НҮБ-аас хүлээн зөвшөөрч, нэн буурай хөгжилтэй гэж ангилсан орнуудад бараа, бүтээгдэхүүнээ татваргүй оруулах эрхийг зэвсгээс бусад худалдаанд үргэлжлүүлэн олгоход зориулсан.

НҮБ-ын нэн буурай хөгжилтэй орны ангиллаас хасагдсан орны хувьд энэхүү зохицуулалтын хүрээнд үзүүлж байсан тарифын хөнгөлөлт хүчингүй болсны улмаас үүсэж болох хүндрэлийг багасгах зорилгоор шилжилтийн хугацааг тогтооно.

Нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан хөнгөлөлтийн тусгай зохицуулалт нь Европын Холбооноос хэрэгжүүлж буй зах зээлд нэвтрэх бусад төрлийн хөнгөлөлтийн зохицуулалтаар үргэлжилнэ.

(17) Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрт тусгагдсан элсэн чихрийн зах зээлд нэвтрэх заалтыг хэрэгжүүлэх үүднээс Гаалийн Нэгдсэн Тарифын 1701 бүлгийн бүтээгдэхүүний импортод 2015 оны 9 дүгээр сарын 30 хүртэл импортлох тусгай зөвшөөрөл шаардана.

(18) Хамтын нийгэмлэгийн ижил төстэй бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй салбарын нөхцөл, байдлыг харгалзан үзэх зорилгоор бараа, бүтээгдэхүүний мэдрэмтгий, мэдрэмтгий бус гэж ялгах замаар мэдрэмтгий байдлыг харгалзаж ялгаатай хөнгөлөлт олгох бодлогыг үргэлжлүүлнэ.

(19) Мэдрэмтгий бус бараа, бүтээгдэхүүний тарифыг тэглэх явцыг үргэлжлүүлэхийн сацуу мэдрэмтгий бараа, бүтээгдэхүүний тарифын ханамжит түвшинг хангахуйц бууруулах бөгөөд чингэхдээ Хамтын нийгэмлэгийн холбогдох үйлдвэрийн салбаруудын нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

(20) Ийм тарифын бууралт нь хөнгөлөлтийн системийн олгож буй бололцоог ашиглах худалдаачдын сонирхлыг хангалттай өдөөхүйц байх ёстой. Гаалийн үнээс хувиар бодох татварын хувьд Нэн тааламжтай нөхцөлийн тарифыг 3.5 пунктээр бууруулна. Сүлжмэл нэхмэл бүтээгдэхүүний хувьд 20 хувиар бууруулна. Барааны нэгжид мөнгөн илэрхийллээр ногдуулах тусгай татварыг 30 хувиар бууруулна. Хамгийн доод түвшний татварын хувийг заасан тохиолдолд энэхүү татварыг ногдуулахгүй.

(21) Энэхүү хөнгөлөлтийн дүнд импортын мэдэгдлийн үнээс хувиар бодох татвар нь 1 хувь буюу түүнээс бага байх эсвэл барааны нэгжид мөнгөн илэрхийллээр ногдуулах татвар нь 2 Евро буюу түүнээс бага байх тохиолдолд олох орлого нь татвар хураах зардлаас бага байх магадлалтай тул дээрх татварыг бүхэлд нь хүчингүй болгоно.

(22) Тус хөнгөлөлтөөс хасахад Гаалийн нэгдмэл тарифын бүлэг болон хэсгүүдтэй

холбогдсон шалгуур, үзүүлэлт дээр үндэслэнэ.

Хөнгөлөлтөөс хасахдаа хэсэг болон дэд хэсгийн хэмжээнд хамааруулан үзэх нь олон бүтээгдэхүүнийг хамрагдах эрсдлийг бууруулна. Хэрэв дараалсан гурван жилд шалгуурыг хангасан бол импортын статистикийн ихээхэн хэмжээний гажуудлын нөлөөг арилгах замаар хөнгөлөлтөөс хасах үйл ажиллагааг ойлгомжтой, шударга болгохын тулд хөнгөлөлт эдлэгч улсын барааны хэсгийг болон дэд хэсгийг хөнгөлөлтөөс хасаж болно.

Тогтвортой хөгжил, сайн засаглалын бодлогыг хэрэгжүүлэгч хөнгөлөлт эдлэгч орнууд болон эдийн засгийн бааз суурь багатай нэн буурай хөгжилтэй орнуудад энэхүү хөнгөлөлтөөс хасах бодлого үйлчлэхгүй.

⁽²³⁾ Хамтын нийгэмлэгийн Гаалийн кодыг батлах тухай Зөвлөлийн 2913/92¹ тоот журмыг хэрэгжүүлэх асуудлыг тусгасан Комиссын 1993 оны 7 дугаар сарын 2-ны 2454/93 тоот журамд заасан бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн үзэл баримтлалын тодорхойлолтын дагуу гарал үүслийн дүрэм журам, холбогдох процедур болон хамтын ажиллагааны арга, хэлбэрийг энэхүү журмын дагуу хөнгөлөлт олгохдоо хэрэглэх бөгөөд ингэснээр зөвхөн хамрагдах ёстой орнуудад л хөнгөлөлтийн системийг олгоно.

⁽²⁴⁾ Энэхүү системийн дагуу хөнгөлөлтөд түр хамааруулахгүй шалтгаан нь хүний үндсэн эрх, хөдөлмөрлөх эрхтэй холбоотой олон улсын конвенцид заасан зарчмуудыг ноцтой, системтэйгээр зөрчсөн тохиолдолд эдгээр конвенцуудын зорилтуудыг дэмжихэд чиглэгдэнэ.

Хөнгөлөлт эдлэгч улс орнууд эдгээр конвенциудыг соёрхон батлах, үр дүнтэй хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй, Европын Холбооны холбогдох үйлдвэрүүдийн нөхцөл байдлыг харгалзан үзээгүй, холбогдох конвенцуудад заасан тайлангийн шаардлагууд, Европын Холбооны хяналт шинжилгээний үйл явцын дагуу хамтран ажиллаагүй бол тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтын хүрээнд эдэлж буй тарифын хөнгөлөлтийг түр хугацаагаар зогсоож болно.

⁽²⁵⁾ Мьянмар, Беларус улс дахь улс төрийн байдлаас шалтгаалан Мьянмар болон Беларус улсаас гарал үүсэлтэй импортын бараа, бүтээгдэхүүнийг тодорхой хугацаагаар хөнгөлөлтөд хамруулахгүй байх шийдвэр хүчинтэй хэвээр байна.

⁽²⁶⁾ Нэг талаас сайжруулсан чиглүүлэлт, даган мөрдөлт болон ил тод байдлын шаардлагууд, болон нөгөө талаастогтвортой хөгжил, сайн засаглал-д сайжруулсан дэмжлэг үзүүлэх нэг талын худалдааны тоголцоог тэнцвэрийг барихын тулд, ЕХ-г үүсгэн байгуулсан тухай гэрээний 290-р зүйлийн дагуу батлах эрх мэдлийг Комисст хуваарилан энэхүү журмын хавсралтад оруулсан өөрчлөлтүүд, тогтвортой хөгжил болон сайн засаглалын бодлогыг мөрдөөгүйгээс болон тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжих тусгай урамшууллын хүрээнд олгосон тарифын хөнгөлөлтийн өргөдөл гаргахтай холбоотой журмын дүрмийг мөрдөөгүйгээс үүдэлтэй тарифын хөнгөлөлтийг

¹ OJ L 253, 1993.10.11, x. 1. Хамгийн сүүлд (ЕХН) Зөвлөлийн журмаар нэмэлт, өөрчлөлт оруулсан журам 837/2005 (OJ L 139, 2005.6.2, x. 1).

түр цуцлана, цогц болон нарийвчилсан зохицуулалтыг бий болгохын тулд мөрдөн байцаалт явуулана. Комисс бэлтгэл ажлын явцад, түүний дотор шинжээчдийн түвшинд, зохих зөвлөлдөөнийг зохион байгуулах нь онцгой ач холбогдолтой юм.

Комисс нь төлөөлж буй үйл ажиллагаагаа бэлтгэж, боловсруулж байхдаа холбогдох бичиг баримтыг Европын Парламент болон Зөвлөлд цаг алдалгүй, зохих ёсоор дамжуулах ёстой.

- (27) Эдийн засгийн операторуудын тогтвортой тогтолцоог бий болгохын тулд ЕХ-г үүсгэн байгуулсан тухай гэрээний 290-р зүйлийн дагуу батлах эрх мэдлийг Комисст тарифын хөнгөлөлтийг түр цуцлах шийдвэр хэрэгжихээс өмнө яаралтай Комисст шилжүүлэх, тарифын хөнгөлөлтийг тур хугацаагаар зогсоох таггалзах тухай шийдвэр гаргахаас өмнө Комисст шилжуулэх ёстой. Түрээслүүлэлтийн шалтгааныг цаашид ашиглахаа больсон тохиолдолд хүчингүй болно.
- (28) Энэхүү журмыг хэрэгжүүлэх нэгдсэн нөхцлийг бүрдүүлэхийн тулд хэрэгжүүлэх эрх мэдлийг Комисст олгох бөгөөд Комиссын гишүүн орнуудын хяналт тавих механизмтай холбоотой дүрэм журам, ерөнхий зарчмуудыг агуулсан 2011 оны 2-р сарын 16-ны өдрийн Европын Парламент болон Зөвлөлийн 182/2011 тоот журмын дагуу хэрэгжих ёстой.
- (29) Хөнгөлөлтийг түр цуцлах тухай үйл ажиллагааны мөн чанар үр дагавар, хөнгөлөлт эдлэгч орныг хүндэтгэн үзэх үүднээс ХЕС-ийн холбогдох хэсгийн тарифын хөнгөлөлтийг түр цуцлах ажиллагааг хэрэгжүүлэх тухай баримт бичгийг батлах үеэр зөвлөх ажиллагааг хэрэглэх ёстой.
- (30) Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх баримт бичгийг батлах болон Европын Холбооны зах зээлд импорт нь ноцтой саад учруулах үед хөнгөлөлтийн зохицуулалтыг түр цуцлахад шалгах үйл ажиллагааг хэрэглэнэ.
- (31) Системийн шударга, дэг журамтай ажиллагааг хангахын тулд гаалийн холбогдолтой журам, үүргийг зөрчсөн болон шаардлагатай үндэслэлийг яаралтай шаардах зэргээс үүдэн хөнгөлөлтийг түр зогсоох арга хэмжээг сунгах болон цуцлах зохих хууль ёсны тохиолдолд Комисс яаралтай хэрэгжүүлж болохуйц баримт бичгийг батлах ёстой.
- (32) Эдийн засгийн операторуудын тогтвортой тогтолцоог хангахын тулд, гаалийн холбогдолтой журам, үүргийг зөрчсөн болон шаардлагатай үндэслэлийг яаралтай шаардах зэргээс үүдэн хөнгөлөлтийг түр зогсоох арга хэмжээг сунгах болон цуцлах зохих хууль ёсны тохиолдолд 6 сар тутамд Комисс яаралтай хэрэгжүүлж болохуйц баримт бичгийг батлах ёстой.
- (33) Мөн түүнчлэн хамгаалалтын арга хэмжээтэй холбоотой хууль ёсны үндэслэл бүхий хэргүүд, шаардлагатай тохиолдолд засвар хийхэд хүндрэл учруулж болох Холбооны үйлдвэрлэгчдийн эдийн засаг, санхүүгийн байдал доройтохтой холбоотой шаардлагатай үндэслэлүүдийг харгалзан Комисс хэрэгжүүлж болохуйц баримт бичгийг яаралтай батална.

⁽³⁴⁾ Комисс нь Европын Парламент болон Зөвлөлд энэхүү журмын дагуу хэрэгжиж буй системийн үр нөлөөний тухай тайланг байнга хүргүүлнэ. Хүчин төгөлдөр үйлчилснээс хойш таван жилийн дараа Комисс Европын Парламент болон Зөвлөлд энэхүү журмын хүсэлт гаргах болон системийг шинэчлэх хэрэгцээнд дүн шинжилгээ хийх, тогтвортой хөгжил болон сайн засаглалын бодлогыг дэмжих тусгай зохицуулалтын арга хэмжээ , тарифын хөнгөлөлтийг түр зуур цуцлах заалт , терроризмын эсрэг тэмцэл, татварын асуудлын ил тод байдал, мэдээлэл солилцох олон улсын стандартуудыг агуулсан тайланг илгээх ёстой.

Тайланд Комисс нь хөнгөлөлт эдлэгч орнуудын хөгжил, худалдаа, санхүүгийн хэрэгцээ шаардлагын үр нөлөөний тухай мэдээллийг агуулсан байх ёстой.

Тайланд мөн энэхүү журмын худалдааны болон Холбооны тарифын орлогод үзүүлэх үр нөлөөний тухай дэлгэрэнгүй судалгааг тусган , ялангуяа хөнгөлөлт эдлэгч орнуудад узуулэх нелееллийг онцгой анхааран тусгах ёстой.

Боломжтой тохиолдолд Холбооны эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн зохицуулалттай холбоотой дагаж мөрдөх шаардлагуудад үнэлэлт дүгнэлт өгнө.

Тайлан нь био түлшний импорт болон тогтвортой байдлын хэтийн төлөвийн талаарх системийн үзүүлж буй нөлөөллийн шинжилгээг багтаах ёстой.

⁽³⁵⁾ Европын Комиссын No 732/2008 тоот журмыг хүчингүй болгон дараах журмыг батлав.

І БҮЛЭГ НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл

1. Тарифын хөнгөлөлтийн ерөнхий систем (цаашид систем гэх) нь энэхүү журмын дагуу хэрэгжинэ.
2. Энэхүү журам нь дараах тарифын хөнгөлөлтүүдийг зохицуулна.
 - (a) ерөнхий хөнгөлөлт,
 - (b) тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын хөнгөлөлт (GSP+)
 - (c) нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай хөнгөлөлт (Зэвсгээс бусад бүх бараа)

2 дугаар зүйл

Энэхүү журмын зорилгууд:

- (a) ХЕС буюу Хөнгөлөлтийн Ерөнхий Систем нь Холбооны зүгээс өөрийн зах зээлд 1 бүлэгт заасан хөнгөлөлтийн зохицуулалтын дагуу хөнгөлөлттэй нэвтрэх боломжоор хангана.
- (b) “Улс орнууд” гэдэг нь гаалийн байгууллагатай улс орон, нутаг дэвсгэрийг хэлнэ
- (c) Эрх бүхий улсууд гэж Хавсралт I-д дурдсан бүх хөгжиж буй орнуудыг хэлнэ
- (d) “ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орнууд” гэдэг нь Хавсралт II-т дурдсан ерөнхий хөнгөлөлт эдлэгч улсуудыг хэлнэ;
- (e) “Шинэчилсэн ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орнууд” ад Хавсралт III-т дурдсан тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын хөнгөлөлт эдлэгч орнууд хамаарна.
- (f) Зэвсгээс бусад бүх барааны зохицуулалтын хөнгөлөлт эдлэгч орнуудад Хавсралт IV-т дурдсан нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай хөнгөлөлт эдлэгч орнууд хамаарна.
- (g) “Гаалийн нэгдмэл тарифын татвар”² гэдэгт тариф ба статистикийн нэр, төрлийн тухай Зөвлөлийн 1987 оны 7 дугаар сарын 23-ны 2658/87 тоот журамд заасан, тарифын квотын хүрээнд тогтоосон татвараас бусад татварыг ойлгоно.
- (h) “Хэсэг” гэдэг нь 2658/87 тоот журмаар батлагдсан Гаалийн нэгдмэл тарифын аль ч хэсэг байж болно.
- (i) Бүлэг ” гэдэг нь 2658/87 тоот журмаар батлагдсан Гаалийн нэгдмэл тарифын аль ч бүлэг байж болно.
- (j) “ХЕС-ийн хэсэг ” гэдэг нь Хавсралт V-д дурдсан Гаалийн нэгдмэл тарифын аль ч хэсэг бүлэг байж болно.
- (k) “Хөнгөлөлттэй зах зээлд нэвтрэх зохицуулалт” нь Холбооны зах зээлд худалдааны гэрээ хэлэлцээрийн дагуу хөнгөлөлттэй байдлаар нэвтрэх үйл ажиллагааг зохицуулна.

² (OJL 256, 1987.9.7, x. 1), (EХН) 493/2005 (OJL 82, 2005.3.31 x.1) тоот журмаар нэмэлт, өөрчлөлт орсон

(l) “үр дүнтэй хэрэгжилт “гэж Хавсралт VIII-д дурдсан олон улсын конвенцийн дагуу хүлээсэн бүхий л үүрэг, хариуцлага, баталсан бүх зарчим, зорилго, эрхийг хэрэгжүүлэх явдлыг хангахад оршино.

3 дугаар зүйл

1. Хөнгөлөлт эдлэгч улсуудын нэрсийг Хавсралт 1-д дурдав.
2. Комисс нь 36 дугаар зүйлийн дагуу олон улсын статус, ангиллын өөрчлөлтийг харгалзан Хавсралт 1-д нэмэлт өөрчлөлт оруулахыг батална.
3. Комисс нь хөнгөлөлтөд хамрагдагч орнуудад тэдгээрийн системийн хүрээн дэх статусын аливаа өөрчлөлтийг мэдэгдэнэ.

БҮЛЭГ II ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАЛТ

4 дүгээр зүйл

1. Хөнгөлөлтөд хамрагдсан орнууд 1 дүгээр зүйлийн (2) дахь хэсгийн (а) -д заасан ерөнхий зохицуулалтын дагуу тарифын хөнгөлөлт эдэлнэ.
(а) Хөнгөлөлт эдлэгч улс нь Дэлхийн банкны өндөр болон дундаас дээш орлоготой орны ангилалд 3 жил дараалан орсон бол энэхүү хөнгөлөлтөөс хасна.
“Гаалийн нэгдсэн тариф” гэдэг нь Зөвлөлийн журмын Хавсралт 1-ийн 2-р хэсэгт тусгагдсан.
(б) Хөнгөлөлт эдлэгч улсууд нь барааны ихэнх худалдааг хамарсан, ижил тарифын хөнгөлөлтийг системийн дагуу эдэлнэ.
2. 1 дэх хэсгийн (а), (б) дэд зүйл нь нэн буурай хөгжилтэй орнуудад хамаарахгүй.

5 дугаар зүйл

1. ХЕС-ийн дагуу хөнгөлөлт эдлэгч улсууд 4 дүгээр бүлгийн Хавсралт II-д заасан шалгуурыг хангасан байна.
2. Энэхүү журмыг хүчин төгөлдөр болсноос хойш жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний дотор Комисс Хавсралт 2-ыг хянан дахин шинэчилнэ.
ХЕС-ийн дагуу хөнгөлөлт эдлэгч улс орон, эдийн засгийн операторуудад энэхүү системийн дагуу улс орны нөхцөл байдлыг өөрчлөхөд дасан зохицох цаг хугацааг олгохын тулд:
(а) Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу болон 4 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн (а) дэд хэсгийн дагуу, хөнгөлөлт эдлэгч улсыг ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч улс орнуудын жагсаалтаас хасах тухай шийдвэр нь баталсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хэрэгжинэ.
(б) Энэ зүйлийн 3 дахь хэсэг болон 4 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн (б) дэд хэсэгт заасны дагуу ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орнуудын жагсаалтаас хасах тухай шийдвэр нь хөнгөлөлтийн зохицуулалтад хамрагдах хүсэлт гаргасан өдрөөс хойш хоёр жилийн дараанаас эхлэн хэрэгжинэ.
3. Энэ зүйлийн 1 ба 2 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор Комисс 36 дугаар зүйлд заасны дагуу 4 дүгээр зүйлд заасан шалгуурыг үндэслэн Хавсралт 2-т нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор эрх зүйн баримт бичгийг төлөөлөн батлах эрхтэй.
4. Комисс хөнгөлөлт эдлэгч улсад тухайн орны системийн хүрээнд орсон статусын аливаа өөрчлөлтийг мэдэгдэнэ.

6 дугаар зүйл

1. Ерөнхий зохицуулалтад хамрагдсан бүтээгдэхүүнүүд нь Хавсралт 5-ийн 1 дүгээр зүйлийн 2 дохь хэсгийн (а) заалтад тусгагдсан болно.
2. Ангиллын Уялдуулсан системд шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулах зорилгоор Комисс 36 дугаар зүйлд заасны дагуу Хавсралт 5-д нэмэлт,

өөрчлөлт оруулах зорилгоор эрх зүйн баримт бичгийг төлөөлөн батлах эрхтэй.

7 дугаар зүйл

1. Хавсралт 5-д заасан, хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүнээс бусад мэдрэмтгий бус бараа, бүтээгдэхүүнийг Гаалийн нэгдмэл тарифын татвараас бүрэн чөлөөлнө.
2. Хавсралт 5-д заасан мэдрэмтгий бараа, бүтээгдэхүүний үнийн дүнд ногдуулах Гаалийн нэгдмэл тарифын татварыг 3.5 пунктээр бууруулна. Хавсралт 5-ийн S-11(а) ба S-11(б) хэсгийн бараа, бүтээгдэхүүний татварыг 20 хувиар бууруулна.
3. Гаалийн нэгдмэл тарифын тухай ЕК №732/2008 журмын 6 дугаар зүйлийн дагуу тооцсон, энэхүү журмыг хүчин төгөлдөр болохоос өмнө хэрэглэж байсан гаалийн үнийн дүнд ногдуулах хөнгөлөлттэй татварын хувь хэмжээ нь энэхүү зүйлийн 2 дугаар заалтад заасан бараа, бүтээгдэхүүний хувьд 3.5 пунктээс илүү буурахаар байвал тэдгээр гаалийн хөнгөлөлттэй татварын хувийг хэрэглэнэ.
4. Хавсралт 5-д дурдсан мэдрэмтгий бараа, бүтээгдэхүүний доод ба дээд түвшний татвараас бусад барааны нэгжид ногдуулах Гаалийн нэгдмэл тарифын татварыг 30 хувиар бууруулна.
5. Хавсралт 5-д мэдрэмтгий бараа, бүтээгдэхүүний Гаалийн нэгдмэл тарифын үнийн дүн болон барааны нэгжид ногдуулах татвар хосолсон тохиолдолд барааны нэгжид ногдуулах татварын хэмжээг бууруулахгүй
6. Энэ зүйлийн 2 болон 4 дүгээр заалтын дагуу бууруулах татвар нь дээд түвшний татвар байх тохиолдолд татварыг бууруулахгүй. Харин доод түвшний татвар байвал доод түвшний татвар нь хүчингүй болно.

8 дугаар зүйл

1. ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орнуудаас гарал үүсэлтэй бараа бүтээгдэхүүнний Холбооны зах зээл дэх импортын өртгийн хэмжээ нь гурван жил дараалан Хавсралт 6-д заасан босгоос хэтэрсэн тохиодолд 7 дугаар зүйлд заасан тарифын хөнгөлөлтийг түдгэлзүүлнэ. ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч бүх улс орнуудын Холбооны зах зээлд импортлосон ижил төрлийн бараа бүтээгдэхүүний импортын нийт өртгийн хувиар босго үзүүлэлтийг тооцно.
2. Энэхүү журамд заасан тарифын хөнгөлөлтийг хэрэглэхээс өмнө, 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөвлөх үйл ажиллагааны дагуу ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орны хувьд 7 дугаар зүйлд дурдсан тарифын хөнгөлөлтийг түдгэлзүүлсэн тухай хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичгийг Комисс батална, Энэхүү хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичгийг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөнө.
3. Комисс гурван жил тутамд энэхүү бүлгийн 2 дугаар хэсэгт дурдсан жагсаалтыг шинэчлэх бөгөөд 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөвлөх үйл ажиллагааны дагуу 7 дугаар зүйлд дурдсан тарифын хөнгөлөлтийг түдгэлзүүлэх болон дахин сайжруулах тухай эрх зүйн баримт бичгийг Комисс батална.
Энэхүү эрх зүйн баримт бичгийг тухайн хүчин төгөлдөр болсон оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

4. Энэ зүйлийн 2 ба 3 дахь хэсэгт дурдсан жагсаалтыг дахин сайжруулахаар ажиллаж буй тухайн оны 9 дүгээр сарын 1-ний өдөр болон өмнөх 2 жилийн мэдээллийг үндэслэн тогтооно.
Тухайн үед Хавсралт 2-д жагсаасан ХЕС-ийн хөнгөлөлөлт эдлэгч орнуудын импортыг харгалзан үзнэ.
Хөнгөлөлтөөс түдгэлзүүлэх хүсэлт гаргасан өдрөөс эхлэн тухайн ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орноос импортолсон бараа бүтээгдэхүүний өртөг 4 (1) дүгээр зүйлийн (b) зүйлийн (b) дэд хэсгийн дагуу тарифын хөнгөлөлтөд хамрагдсан тоон үзүүлэлтэд хамаарахгүй.
5. Комисс 2 ба 3 дугаар зүйлийн дагуу хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг баталсан тухай тухайн хөнгөлөлт эдлэгч улсад мэдэгдэнэ.
6. 4 дүгээр зүйлд заасан шалгуурын дагуу Хавсралт 2-т нэмэлт өөрчлөлт оруулж байгаа бол Комисс нь 36 дугаар зүйлийн дагуу Хавсралт 6-д нэмэлт өөрчлөлт оруулахдаа энэхүү хавсралтын жагсаалтыг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөнгөлөлтөөс хасах бүтээгдэхүүний хэсэгтэй тэнцүү хэмжээгээр хадгалахыг харгалзан эрх зүйн баримт бичгийг төлөөлөн батална.

БҮЛЭГ III
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, САЙН ЗАСАГЛАЛЫН ТУСГАЙ
УРАМШУУЛЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

9 дүгээр зүйл

1. Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтад хамрагдсан ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орнууд 2 дугаар Хавсралтад заасны дагуу тарифын хөнгөлөлт эдэлнэ, үүнд:
 - (a) Хавсралт VII-д дурдсаны дагуу олон улсын худалдаанд төрөлжилт болон интеграцчилал хангалтгүй байгаа,
 - (b) Хавсралт VIII-д дурдсан бүх конвенциудыг (холбогдох конвенцууд) соёрхон баталсан ба эдгээр конвенцуудын хэрэгжилтэд хяналт тавих байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн дүгнэлт (“холбогдох хяналтын байгууллагууд”)
 - (c) Энэ зүйлд заасны дагуу дараахь зүйлээс бусад тохиолдолд конвенцийн зорилго, зорилгод нийцээгүй гэж үзэхгүй:
 - (i) тухайн конвенцийн зорилгод тодорхойлсон үйл явц маш тодорхой болсон; эсвэл
 - (d) Холбогдох конвенцуудыг соёрхон баталсны дагуу заавал биелүүлэх үүрэг хүлээн тэдгээрийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа
 - (e) Конвенци тус бүрт дурдсаны дагуу тайлангийн шаардлагыг тайлбаргүйгээр хүлээн зөвшөөрөх бөгөөд холбогдох конвенцуудын заалтуудын дагуу байнгын мониторинг хийж түүний хэрэгжилтийн тайланг шинэчлэх; болон
 - (f) 13 дугаар зүйлд дурдсан мониторингийн үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах үүрэг хүлээнэ.
2. 2 дугаар хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулсан тохиолдолд, Хавсралт VII-ийн 1-р хавсралтын 1 (b) -д заасан эмзэг байдлын босго хэмжээг тооцоолохын тулд эмзэг байдлын цар хүрээтэй тэнцүү хэмжээгээр хадгалах зорилгоор Хавсралт VII-д нэмэлт хийх үүднээс Комисс нь 36 дугаар зүйлд заасны дагуу эрх зүйн баримт бичгийг төлөөлөн батлах эрхтэй.

10 дугаар зүйл

1. Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтад дараах нөхцлүүд хамрагдана.
 - (a) ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч улсын зүгээс хүсэлт тавьсан;
 - (b) Хүсэлт гаргагч орны хүсэлтийг шалгасан шалгалт нь 9 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан нөхцлийг хангасан.
2. Хүсэлт гаргагч улс хүсэлтээ Комисст бичгээр гаргана. Хүсэлт нь холбогдох конвенцийг соёрхон батлахтай холбоотой иж бүрэн мэдээлэл болон 9 дүгээр зүйлийн (d), (e), (e) (d), (e) хэсгүүдэд дурдсан үүрэг амлалтуудыг агуулсан байна.
3. Хүсэлтийг хүлээн авсны дараа Комисс нь Европын Парламент болон Зөвлөлд мэдэгдэнэ.

4. Хүсэлтийг хянан үзсэний дүнд, тогтвортой хөгжлийг дэмжих, сайн засаглалын тусгай урамшууллыг хэрэгжүүлэгч тухайн улсыг ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орнуудын жагсаалтад нэмэх замаар Хавсралт 3-т нэмэлт оруулах үүднээс Комисс нь 36 дугаар зүйлд заасны дагуу эрх зүйн баримт бичгийг төлөөлөн батлах эрхтэй.
5. Комисс III хавсралтад өөрчлөлт орсны дараа Европын Холбооны албан ёсны сэтгүүлд нийтлэгдсэн энэ зүйлийн 4, 5 дахь хэсэгт нийцүүлэн гаргасан шийдвэрийг хүсэлт гаргагч улсад мэдэгдэнэ. Хүсэлт гаргагч улс тусгай урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх тохиолдолд тухайн эрх зүйн баримт бичиг хүчин төгөлдөр үйлчлэх өдрийг мэдэгдэнэ.
6. Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтыг олгох журам, ялангуяа хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаа, хүргүүлэхтэй холбоотой журмуудыг тогтоох үүднээс Комисс нь 36 дугаар зүйлд заасны дагуу эрх зүйн баримт бичгийг төлөөлөн батлах эрхтэй.

11 дүгээр зүйл

1. Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтад орсон бүтээгдэхүүнүүдийг Хавсралт IX-д жагсаав.
2. Хавсралт IX-д хамрагдсан бүтээгдэхүүний Нэгдсэн нэр томъёоны жагсаалтад өөрчлөлт хийх үүднээс Комисс нь 36 дугаар зүйлд заасны дагуу эрх зүйн баримт бичгийг төлөөлөн батлах эрхтэй.

12 дугаар зүйл

1. Хавсралт IX-д дурдсан хөнгөлөлт эдлэгч орнуудаас гарал үүсэлтэй бүх бараа бүтээгдэхүүнийг үнийн дүнд ногдуулах Гаалийн нэгдмэл тарифын татвараас чөлөөлнө.
2. Үнийн дүнд болон биет хэмжээнд ногдуулах татвар хосолсон Гаалийн нэгдмэл тариф бүхий бараа, бүтээгдэхүүнээс бусад 1 дүгээр заалтад дурдсан бараа, бүтээгдэхүүнийг Гаалийн нэгдмэл тарифын биет хэмжээнд ногдуулах татвараас бүрэн чөлөөлнө. 17041090 гэсэн кодтой бараа, бүтээгдэхүүний хувьд биет хэмжээнд ногдуулах татвар нь гаалийн үнэлгээний 16 хувиас хэтрэхгүй байна.

13 дугаар зүйл

1. Тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтын хүрээнд тарифын хөнгөлөлт үзүүлэх өдрөөс Комисс нь холбогдох конвенцийг соёрхон батлах байдлыг хянан үзэж хяналт шалгалтын байгууллагуудын дүгнэлт, зөвлөмжийг хянан үзэх замаар үр дүнтэй хэрэгжилт, түүнчлэн холбогдох хяналтын байгууллагатай хамтран ажиллана.
2. Энэ хэсэгт дурдсанчлан ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч улсууд нь Комисстай хамтран ажиллаж, 9 дүгээр зүйлийн (d), (e) ба (e) дэд хэсгүүдэд дурдсан заавал биелүүлэх үүрэг болон 9 дүгээр зүйлийн (1) дахь хэсгийн (a) заалтын дагуу шаардлагатай бүх мэдээллээр хангана.

14 дүгээр зүйл

1. 2016 оны 1-р сарын 1 гэхэд үүнээс хойш хоёр жил тутам, Комисс нь холбогдох конвенцуудыг соёрхон баталсан тухай статус, ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орнуудын тухайн конвенцуудын дагуу хүлээсэн үүргийн талаарх санал болон түүний үр дүнтэй хэрэгжилтийн байдлын тухай тайланг Европын Парламент болон Зөвлөлд танилцуулна.
2. Тухайн тайлан дараах мэдээллийг агуулсан байна:
 - (a) ХЕС-ийн дагуу хөнгөлөлт эдлэгч орнуудын холбогдох хяналтын байгууллагуудын дүгнэлт, зөвлөмж; болон
 - (b) ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орон бүрийн тайлагнах үүргээ биелүүлэхтэй холбогдон хүлээх үүрэг хариуцлага, холбогдох хяналтын байгууллагуудтай конвенцуудын дагуу хамтран ажиллах, тэдгээрийг үр дүнтэй хэрэгжүүлэх явдлыг хангах тухай Комиссын дүгнэлт.
 Тайланд Комисс шаардлагатай гэж үзсэн аливаа мэдээллийг багтааж болно.
3. Холбогдох конвенциудын хэрэгжилтийн үр дүнгийн талаарх дүгнэлтийг гаргахдаа Комисс холбогдох хяналтын байгууллагуудын дүгнэлт, зөвлөмж, мөн бусад эх сурвалжууд болох хөндлөнгийн гуравдагч этгээд, түүний дотор иргэний нийгэм, нийгмийн түншүүдээс ирүүлсэн мэдээллийг үндэслэнэ.

15 дугаар зүйл

1. Тогтвортой хөгжлийн болон сайн засаглалын тусгай урамшууллын зохицуулалтыг түр хугацаагаар цуцлахдаа ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орны гарал үүсэлтэй бүх буюу зарим бүтээгдэхүүний хувьд 9 дүгээр зүйлийн 1 (e), (e) ба (e) дэд хэсгүүдэд дурдсан улс орон өөрийн заавал дагаж мөрдөх үүргийг хүндэтгэхгүй байх, ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч улс 9 (1) дүгээр зүйлийн (c) -д тодорхойлсон конвенцийн зорилго, зорилготой зөрчилдөх ямар нэг холбогдох конвенциор хориглосон тайлбарыг боловсруулсан.
2. 9 дүгээр зүйлийн (1) дэх хэсгийн (d), (e) ба (e) дэд хэсгүүдэд заасан хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болох 9 дүгээр зүйлийн (c) (1) нь ХЕС-ийн ашиг хүртэгч улс оронд байна.
3. ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орон 9 дүгээр зүйлийн (г), (д) ба (e) дэд хэсгүүдэд дурдсан улс орон заавал дагаж мөрдөх үүргийг хүндэтгэхгүй байх, 9 (1) дүгээр зүйлийн (c) -д тодорхойлсон нэгдэн орсон конвенцуудын зорилготой зөрчилдөх тайлбарыг гаргасан тохиолдолд Комисс нь 14 дүгээр зүйлийн тайлангийн дүгнэлт эсвэл холбогдох нотлох баримт дээр үндэслэж 39 дүгээр зүйлийн (2) -т заасан журмын дагуу тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжих тарифын хөнгөлөлтийг түр хугацаагаар зогсоох акт гаргана. Комисс нь Европын парламент болон Зөвлөлд мэдэгдэнэ.
4. Комисс нь мэдэгдлийг Европын Холбооны албан ёсны сэтгүүлд нийтэлж, ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орнуудад энэ талаар мэдэгдэнэ
Мэдэгдэл нь:
 - (a) 9 (1) зүйлийн (в), (г), (д) -т заасны дагуу ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орнуудын хүлээсэн үүргийн биелэлт, эсхүл үндэслэлтэй эргэлзээний үндэслэлийг хэлж өгнө. холбогдох конвенцоор хориглосон эсвэл 9 (1) зүйлийн (в) хэсэгт

- заасны дагуу тухайн конвенцийн зорилго, зорилготой нийцэхгүй, энэ нь үргэлжлүүлэн хийх эрхийг нь эргэлзээ төрүүлж болзошгүй. тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжих тусгай урамшууллын хүрээнд олгосон тарифын давуу талыг ашиглах; ба
- (b) мэдэгдлийг нийтэлсэн өдрөөс хойш зургаан сараас хэтрэхгүй хугацааг зааж өгөх ба үүнд ХЕС-ийн ашиг хүртэгч улс өөрийн саналаа ирүүлнэ.
5. Комисс 4-р зүйлийн (б) хэсэгт заасан хугацаанд хамтран ажиллах бүхий л боломжийг хөнгөлөлт эдлэгч орнуудад олгоно.
 6. Комисс шаардлагатай гэж үзсэн бүх мэдээллийг, үүнд холбогдох хяналтын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг оруулан хайна. Дүгнэлт гаргахдаа Комисс холбогдох бүх мэдээллийг үнэлнэ.
 7. Мэдэгдэлд дурдсан хугацаа дууссанаас хойш гурван сарын дотор Комисс шийдвэрлэнэ.
 - (a) түр хугацаагаар татах журмыг цуцлах; эсвэл
 - (b) тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжих тусгай урамшууллын хүрээнд олгосон тарифын хөнгөлөлтийг түр хугацаагаар хасах.
 8. Комиссын тогтоосон үр дүн нь түр хугацаагаар татан буулгах үндэслэлгүй гэж үзвэл 39 (2) -т заасан зөвлөх журмын дагуу түр хугацаагаар татан буулгах журмыг цуцлах тухай акт үйлдэнэ. Энэхүү хэрэгжүүлсэн акт нь хүлээн авсан нотлох баримтад үндэслэнэ.
 9. Комиссын дүгнэлт нь энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан шалтгаанаар түр хугацаагаар татан буулгах үндэслэлтэй гэж үзвэл энэ нь 36 дугаар зүйлд заасны дагуу 1 (2) зүйлийн b) хэсэгт заасан тогтвортой хөгжүүлэлт, сайн засаглалыг дэмжих тусгай урамшууллын зохицуулалтын дагуу олгосон тарифын хөнгөлөлтийг түр хугацаагаар хасах зорилгоор III хавсралтад нэмэлт оруулах тухай төлөөлсөн актуудыг батлах эрх мэдлийг олгоно.
 10. Комисс түр хугацаагаар татан буухаар шийдвэрлэсэн тохиолдолд ийм төлөөлөх акт батлагдсан өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.
 11. Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан төлөөлөх акт хүчин төгөлдөр болохоос өмнө түр хугацаагаар цуцлах үндэслэл байхгүй бол Комисс нь 37 дугаар зүйлд заасан яаралтай журмын дагуу тарифын хөнгөлөлтийг түр хугацаагаар буцааж авахаар батлагдсан актыг хүчингүй болгох бүрэн эрхтэй.
 12. Комисс нь 36 дугаар зүйлд заасны дагуу тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжих хөшүүргийн тусгай арга хэмжээг түр хугацаагаар татан авах журам, ялангуяа хугацаа, талуудын эрх, нууцлал, хянан шалгахтай холбогдсон дүрмийг бий болгох төлөөлөх актуудыг батлах эрхтэй.

16 дугаар зүйл

Зүйл 15 (1)-т заасны дагуу тарифын хөнгөлөлтийг түр хугацаагаар хасах үндэслэлүүд гарахгүй гэж Комисс үзвэл тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжих хөшүүргийн тусгай зохицуулалтын дагуу олгосон тарифын хөнгөлөлтийг сэргээх зорилгоор 36 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөх актуудыг батлах эрхтэй.

БҮЛЭГ IV
НЭН БУУРАЙ ХӨГЖИЛТЭЙ ОРНУУДАД ЗОРИУЛСАН ТУСГАЙ
ЗОХИЦУУЛАЛТ

17 дугаар зүйл

1. Хэрэв тухайн улс нь НҮБ-ын нэн буурай хөгжилтэй орнуудын жагсаалтад хамрагдсан бол нэгдүгээр бүлгийн (2) зүйлийн (с) хэсэгт заасан нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан тусгай зохицуулалтын дагуу тарифын хөнгөлөлт эдлэх эрхтэй.
2. Комисс нь хамгийн сүүлийн үеийн боломжит мэдээлэлд үндэслэн “Зэвсгээс бусад бүх юм” (ЕВА) нөхцлийн тусгай хөнгөлөлт эдлэгч орнуудын жагсаалтыг тасралтгүй шинэчилнэ. Хэрэв ЕВА нөхцлийн хөнгөлөлт эдлэгч орон энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангахгүй тохиолдолд 36 дугаар зүйлд заасны дагуу тухайн төлөөлсөн акт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гурван жилийн хугацаатай шилжилтийн үеийг даван туулсан тухайн орныг ЕВА хөнгөлөлт эдлэгч орнуудын жагсаалтаас хасахын тулд IV хавсралтад өөрчлөлт оруулах зорилгоор Комисс нь дахин төлөөлсөн акт батлах эрхтэй.
3. НҮБ-аас шинээр тусгаар тогтносон улсыг өндөр хөгжилтэй, буурай хөгжилтэй улс хэмээн тодорхойлохыг хүлээх хугацаанд Комисс нь 36 дугаар зүйлд заасны дагуу тухайн улсыг ЕВА хөнгөлөлт хүртэх орнуудын жагсаалтад оруулах зорилгоор түр зуурын арга хэмжээ болгон IV хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөөлсөн актуудыг батлах эрхтэй. Хэрэв тухайн шинээр тусгаар тогтносон улсыг НҮБ-аас нэн буурай хөгжилтэй орнуудын ангилалд хамрагдах талаар хийсэн анхны үнэлгээний үеэр нэн буурай хөгжсөн орон гэж тодорхойлж чадаагүй бол Комисс 36 дугаар зүйлд заасны дагуу энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шилжилтийн хугацааг оруулахгүйгээр тухайн улс орныг хасахын тулд IV хавсралтад нэмэлт оруулах тухай төлөөлсөн акт батлах бүрэн эрхтэй.
4. Комисс ЕВА хөнгөлөлт эдлэгч орнуудын статусын өөрчлөлтийн талаар мэдээлэх үүрэгтэй.

18 дугаар зүйл

1. Нэгдсэн Гаалийн Тарифын татвар нь Нэгдсэн Жагсаалтын 1-ээс 97-р бүлгийн бүх бараанд хамаарна. 2014 оны 1 дүгээр сарын 1-ээс 2015 оны 9-р сарын 30-ны хугацаанд Нэгдсэн Гаалийн Тарифын 1701 код бүхий барааг импортлоход импортын тусгай зөвшөөрөл шаардлагатай болно.
2. Комисс 39 (3) -д заасан шалгалтын журмын дагуу хөдөө аж ахуйн соёлын зах зээлийн нийтлэг зохион байгуулалтыг бий болгох ба зарим агрегат соёлын бүтээгдэхүүний тодорхой заалтууд (СМО-ийн нэг журам) (1),
3. энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан заалтыг хэрэгжүүлэх талаар нарийвчилсан дүрмийг Зөвлөлийн 2007 оны 10-р сарын 22-ны ЕС 1234/2007 дугаар журмын 195-р зүйлд заасны дагуу батална.

БҮЛЭГ V
ТҮР ЦУЦЛАЛТ БА НИЙТЛЭГ БҮХ ЗОХИЦУУЛАЛТ*19 дүгээр зүйл*

1. Хөнгөлөлт эдлэгч улсаас гаралтай бүх буюу зарим бүтээгдэхүүний хувьд энэхүү журмын Зүйл 1(2)-д заасан хөнгөлөлтийн зохицуулалтыг дараах аль нэг шалтгаанаар түр цуцалж болно. Үүнд:
 - (a) VII дугаар Хавсралтын А хэсэгт жагсаасан конвенцуудад заасан зарчмыг ноцтойгоор болон удаа дараа зөрчсөн тохиолдолд
 - (b) шоронд хоригдогсдын хөдөлмөрөөр бүтсэн бараа, бүтээгдэхүүний экспорт,
 - (c) хууль бус мансууруулах бодисын экспорт, дамжин тээвэрлэлтэд тавих гаалийн хяналтад ноцтой зөрчил, дутагдал илэрсэн буюу терроризмын эсрэг „мөнгө угаах гэмт хэргийн тухай олон улсын конвенцийг дагаж мөрдөөгүй,
 - (d) Хамтын нийгэмлэгийн аж үйлдвэрт сөрөг нөлөөтэй, хөнгөлөлт эдлэгч улс анхаарч шийдвэрлээгүй худалдааны шударга бус практикийн ноцтой хэлбэр буюу удаа дараагийн үйлдэл; ДХБ-ын хэлэлцээрүүдээр хориглосон буюу арга хэмжээ авах худалдааны шударга бус практикийн тухай энэхүү зүйлийг хэрэглэхдээ ДХБ-ын эрх бүхий байгууллагын өмнөх шийдвэрийг үндэслэл болгох,
 - (e) Хамтын нийгэмлэгийн нэгдэн орсон загасны нөөцийг хадгалах, зохицуулах тухай бүс нутгийн загасны аж ахуйн байгууллага буюу гэрээ, хэлэлцээрийн зорилтыг ноцтойгоор буюу удаа дараа зөрчих
2. Европын хамтын нийгэмлэгийн гишүүн биш орнуудаас оруулсан татаастай импортоос хамгаалах тухай 2009 оны 6-р сарын 11-ний өдрийн Зөвлөлийн журам (ЕС) 597/2009 ба Европын хамтын нийгэмлэгийн гишүүн биш улсуудаас импортолсон импортыг хамгаалах тухай 2009 оны 11-р сарын 30-ны өдрийн 1225/2009 тоот Зөвлөлийн дүрэм (ЕС)-д заасны дагуу демпингтэй тэмцэх, дарангуйллын эсрэг арга хэмжээ авах шаардлагатай байгаа бүтээгдэхүүний хувьд энэ журамд заасан хөнгөлөлт 1-р зүйлийн (d) хэсэгт заасны дагуу татгалзаж болохгүй.
3. Комисс энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан шалтгааны үндсэн дээр Зүйл 1 (2) -т заасан аливаа хөнгөлөлттэй зохицуулалтын дагуу олгосон тарифын хөнгөлөлтийг түр хугацаагаар татаж авах хангалттай үндэслэл байгаа гэж үзвэл 39 (2) -т заасан зөвлөх журмын дагуу түр хугацаагаар татан авах журмыг эхлүүлэх үүднээс хэрэгжүүлэх акт батална. Комисс Европын парламент, Зөвлөлд тухайн хэрэгжүүлэх актыг талаар мэдээлнэ.
4. Комисс нь Европын Холбооны албан ёсны сэтгүүлд түр цуцлалтын үйл ажиллагааны тухай зарлаж, хөнгөлөлт эдлэгч орнуудад мэдэгдэнэ. Мэдэгдэл нь:
 - (a) 3-р зүйлд заасан түр хугацаагаар цуцлах тухай журмыг хэрэгжүүлэх актыг хангалттай үндэслэлээр хангах
 - (b) мэдэгдлийг нийтэлсэн өдрөөс хойш зургаан сарын хугацаанд Комисс холбогдох хөнгөлөлт эдлэгч улс орны нөхцөл байдалд хяналт тавьж, үнэлгээ хийнэ.

5. Комисс хөнгөлөлт эдлэгч улсад хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад хамтран ажиллах бүх боломжийг олгоно.
6. Комисс шаардлагатай тохиолдолд холбогдох хяналтын байгууллагуудын бэлэн байгаа үнэлгээ, санал, шийдвэр, зөвлөмж, дүгнэлт зэрэг бүхий л мэдээллийг хайж олох болно.
Дүгнэлт гаргахдаа Комисс холбогдох бүх мэдээллийг үнэлнэ.
7. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн (b) -д заасан хугацаа дууссанаас хойш гурван сарын хугацаанд Комисс өөрийн олсон үр дүн, дүгнэлтээ холбогдох хөнгөлөлт эдлэгч улсад илгээнэ. Хөнгөлөлт эдлэгч улс тайланд нэмэлт тайлбараа оруулах эрхтэй. Тайлбар оруулах хугацаа нэг сараас хэтрэхгүй байна.
8. 4 дэх хэсгийн (b) хэсэгт заасан хугацаа дууссанаас хойш зургаан сарын дотор Комисс дараах шийдвэр гаргана:
(a) түр цуцлах журмыг зогсоох,эсвэл
(b)Зүйл 1 (2) -т заасан хөнгөлөлттэй зохицуулалтын дагуу олгосон тарифын хөнгөлөлтийг түр цуцлах
9. Комиссын олсон үр дүн нь түр цуцлах үндэслэл болохгүй гэж үзвэл Зүйл 39 (2) -т заасан зөвлөх журмын дагуу түр цуцлалтыг дуусгавар болгох тухай. хэрэгжүүлэх акт үйлдэнэ.
10. Комиссын дүгнэлт нь энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан шалтгаанаар түр цуцлах үндэслэлтэй гэж үзвэл Зүйл 1 (2) -т заасан хөнгөлөлттэй зохицуулалтын дагуу олгосон тарифын хөнгөлөлтийг түр цуцлах зорилгоор.36 дугаар зүйлд заасны дагуу II, III, IV хавсралтад өөрчлөлт оруулахаар төлөөлсөн акт батлах эрхтэй.
11. Догол мөр 9, 10-т дурдсан батлагдсан акт нь хүлээн авсан нотлох баримтад үндэслэнэ.
12. Комисс түр цуцлах шийдвэр гаргасан тохиолдолд тухайн төлөөлсөн акт нь батлагдсанаас хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.
13. Энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан төлөөлсөн актын хүчин төгөлдөр болохоос өмнө түр цуцлах үндэслэл байхгүй бол Комисс 37 дугаар зүйлд заасан яаралтай журмын дагуу тарифын хөнгөлөлтийг түр цуцлахаар батлагдсан актыг хүчингүй болгох бүрэн эрхтэй.
14. Комисс нь 36 дугаар зүйлд заасны дагуу хугацаа, талуудын эрх, нууцыг хадгалах, хянан шалгахтай холбоотой бүх зохицуулалтыг түр хугацаагаар цуцлах журамтай холбоотой дүрмийг бий болгох зорилгоор төлөөлсөн акт батлах эрхтэй.

20 дугаар зүйл

Хороо нь Зүйл 19 (1) -т заасан тарифын хөнгөлөлтийг түр цуцлах үндэслэлүүд цаашид ашиглагдахаа больсон гэж үзвэл Зүйл 1 (2) -т заасан хөнгөлөлттэй зохицуулалтын дагуу олгосон тарифын хөнгөлөлтийг сэргээх зорилгоор. II, III, IV Хавсралтад өөрчлөлт оруулах тухай 36 дугаар зүйлд заасны дагуу төлөөлсөн акт батлах эрхтэй.

21 дүгээр зүйл

1. Энэхүү журамд заасан хөнгөлөлттэй арга хэмжээг хөнгөлөлт эдлэгч улсаас гарал үүсэлтэй бүх төрлийн болон тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүнийг

